

## Цар тахлын үеийн шинэ үгийн хэллэгийн онцлог, хэрэглээ

Г.Гэрэлмаа

[gerelmaa2003@gmail.com](mailto:gerelmaa2003@gmail.com); [gerelmaag@mas.ac.mn](mailto:gerelmaag@mas.ac.mn)

976-450480; 976-99718891; 976-96718891

ШУА-ийн Хэл зохиолын хүрээлэнгийн ЭШТА,  
доктор (Ph.D), дэд профессор

Аливаа хэлний үгийн сан нь нийгэм цаг үеийн үйл явдлыг тусгасан үг хэллэгээр ямагт баяжиж байдаг билээ. Дэлхий нийтийг хамарсан цар тахал болох Корона вирус халдвар түүнээс хамгаалах, дархлаажуулахтай холбоотой үг хэллэг нийтлэг тархсан нь монгол хэлэнд ч адил байна. Эдгээр шинэ үг нь дараах 2 байдлаар үгийн санд орж ирсэн байна.

1. Бичгийн хэлээр дамжин шинэ үг орж ирсэн. Монгол улсын баталсан 2020 оны 04 сарын 29-ний өдөр “Коронавируст халдвар (ковид-19)-ын цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх, нийгэм, эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах тухай” 4 бүлэг 19 зүйлтэй хууль болон ковидын тухай олон улсын байгууллагын мэдэгдэл, гэрээ зэрэг албан баримтаар дамжин олон шинэ үг хэллэг монгол хэлэнд орж ирэв. Жишээлбэл, “тохиолдол”, “сэжигтэй тохиолдол”, “батлагдсан тохиолдол”, “халдвар”, “хөл хорио”, “тусгаарлах”, “ажиглах” гэх мэт.

2. Мэдээ мэдээллээр дамжин орж ирсэн шинэ үгс нь гол төлөв орчуулгын үгс байна.

а. Монгол хэлээрх шинэ үгс: “халдварлагдсан”, “халдваргүйжүүлэлт”, “хүн хоорондын зай”, “ойрын хавьтал”, “нэгдүгээр хавьтал”, “мутац”, “сүргийн дархлаа”, “ногоон бүс”, “улбар шар түвшин”, “тандалт судалгаа”, “эерэг”, “сөрөг”, “амны хаалт” гэх мэт.

б. Англи хэлний оноосон нэр тэр хэвээр орж ирсэн байна. Вирусийн оноосон нэр COVID-19, “альфа вирус”, “делта вирус”, “омега вирус” “ПИ СИ АР”, “омикрон”, “Файзер вакцин”, “Астразинеика вакцин”, “Модерна вакцин” гэх мэт.

в. Харь хэлний болон монгол хэлний үг холилдсон нийлмэл шинэ үгс. Жишээ нь, “ковидын шинжилгээ”, “ковидын эмчилгээ”, “ковидын эм”, “дархлаажуулалт”, “вакцин”, “нэгдүгээр тун”, “хоёрдугаар тун”, “гуравдугаар тун”, “дөрөвдүгээр тун” гэх мэт.

г. Зөвхөн цар тахалтай холбоотойгоор анагаах ухааны салбарт хэрэглэгдэх нэр томъёо шинээр орж ирсэн. “улаан бүс”, “идэвхтэй халдвар”, “тусгаарласан өрөө”, “халдварын үе”, “явуулын дархлаажуулах цэг” гэх мэт.

Эдгээр шинэ үгийн утга, орчуулга нь эх хэлний хэм хэмжээнд тохиромжтой болон үл тохирох зүйл байгааг бид засаж залруулах үүрэгтэй билээ.

**Цар тахал** хэмээх хэллэг нь шинээр үүссэн бөгөөд өмнө нь анагаахын шинжлэх ухаанд эпидеми хэмээх үгийг “тахал” хэмээн нэрлээд “цөөн бүс нутагт дэлгэрсэн халдварт өвчин”-ийг нэрлэдэг байсан бол “пандеми” нь “улс орон бүхэлдээ болон дэлхий нийтэд тархсан халдварт өвчин”-ий нэр тул түүнийг монгол хэлнээ “цар тахал” хэмээсэн нь оновчтой нэрлэлт юм. Харин **Сүргийн дархлаа** нь англи хэлний “herd immunity”-ийн үгчилсэн орчуулга бөгөөд монгол “*Сүргийн дархлаа*” гэвэл “мал сүргийн дархлаа” гэж ойлгохоос “хүний” гэж ойлгохгүй тул “Хүн амын дархлаа”, “нийтийн дархлаа” гэх зэргээр оноовол оновчтой болно.

## Characteristics and usages of neologism during the pandemic

G.Gerelmaa

Institute Language and literature  
of Mongolian Academy of Sciences

The lexicon of any language is always enriched with words that reflect the current events of the society. Words related to protection and immunization against the Corona virus infection, which is a global pandemic, are common in the Mongolian language as well. These new words entered the vocabulary in the following 2 ways.

1. Introduction of neologism through written language. On April 29, 2020, adopted by Mongolia, the 4-chapter 19-item law "On preventing and combating the spread of the coronavirus (covid-19) and reducing its negative impact on society and economy" and the statement of the international organization on covid, many new words entered the Mongolian language through official documents such as contracts. For example, "case", "suspected case", "confirmed case", "infection", "quarantine", "isolation", "observation", etc.
2. Neologism introduced through the news are mostly translation words.
  - a. Neologism in Mongolian: "infected", "decontamination", "interpersonal distance", "close contact", "first contact", "mutation", "herd immunity", "green zone", "orange level", "surveillance research", "positive", "negative", "mouth mask", etc.
  - b. The English proper name has remained the same. Names given to the virus are COVID-19, "alpha virus", "delta virus", "omega virus", "PSR", "omicron", "Pfizer vaccine", "Astrazymeika vaccine", "Moderna vaccine", etc.
  - c. Compound new words that are a mixture of foreign and Mongolian words. For example, "covid test", "covid treatment", "covid drug", "immunization", "vaccine", "first dose", "second dose", "third dose", "fourth dose", etc.
  - d. It is only in connection with the pandemic that new terms have been introduced into the medical field. "red zone", "active infection", "isolation room", "epidemic period", "travel immunization point", etc.

The meaning and translation of some new words match the standard Mongolian language. The term "epidemic-**tsar takhal**" is new, and earlier in medical science, the word "epidemic" was called "takhal" and meant "infectious disease spread over a small area." But this "infectious disease" is an infectious disease spread internationally, so it is appropriate to call it "tsar takhal" in Mongolian.

"**Surgiin darkhlaa**" is a literal translation of the English word "herd immunity". Mongolian "Surgiin darkhlaa" means "herd immunity" and not "human", so it would be more appropriate to assign it as "population immunity" or "general immunity".